



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 98


Улаанбаатар хот

“Үндэсний давхар даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэр

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.9, 62.1.15, 77 дугаар зүйлийн 77.1, 77.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 21.1 дэх хэсэг, “Хөдөө аж ахуйн давхар даатгалын хуулийн этгээдийг үүсгэн байгуулах тухай” Засгийн газрын 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 280 дугаар тогтоол, ““Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн нэрийг өөрчлөх тухай” Засгийн газрын 2018 оны 303 дугаар тогтоол, Сангийн сайдын 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 109 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” хаалттай хувьцаат компанийн дүрмийн 4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг улируулан сонгосугай.
3. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг хавсралт ёсоор баталсугай.
4. Компанийн үйл ажиллагааг үр дүнтэй, оновчтой зохион байгуулж, батлагдсан зорилтот түвшинд хүрэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн, тайлагнаж ажиллахыг “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Жавхлант/-д үүрэг болгосугай.
5. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Ч.Тавинжил/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ,
САНГИЙН САЙД



Б.ЖАВХЛАН

9763000450

Сангийн сайдын
2023 оны 05 дүгээр сарын 01 өдрийн
.98 тушаалын хавсралт

**"ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ" ХК-ИЙН
2023 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН**

(мянган төгрөгөөр)

№	Эдийн засгийн үзүүлэлт	2022 он			2023 оны төсөв	Харьцуулалт 2023 төс/2022 гүйц	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өсөлт/бууралт %	2023 оны төсөв	Зөрүү	Хувь
	А	Б	В		Г	Д=(Г-В)	Е=(Г/В)
1	Орлогын дүн	9,988,186.06	9,196,363.17	-7.93%	12,294,434.42	3,098,071.25	1.34
	Төсвөөс урсгал санхүүжилт	-	-	0.00%	-	-	-
	Нийт даатгалын хураамж (дээд, дунд түвшин)	5,796,966.36	4,078,642.44	-29.64%	6,620,698.96	2,542,056.52	1.62
	Хөрөнгө оруулалт, үндсэн үйл ажиллагааны орлого	4,191,219.70	4,956,652.09	18.26%	5,673,735.46	717,083.37	1.14
	Бондын өгөөж	-	-	0.00%	-	-	-
	Бусад орлого	-	161,068.64	0.00%	-	(161,068.64)	-
2	Даатгалын зардал	5,198,842.50	2,845,979.05	45.26%	3,644,993.04	799,013.99	1.28
	Нийт төлсөн нэхэмжлэл /нөхөн төлбөр/	520,873.68	184,506.47	64.58%	599,381.00	414,874.53	3.25
	Нөхөн төлбөрийн нөөц сангийн зардал	2,105,013.09	809,551.32	61.54%	132,599.30	(676,952.02)	0.16
	Гадаад шилжүүлэг /ОУ-ын ДД-ын зардал/	2,341,077.07	1,598,285.62	31.73%	2,646,184.78	1,047,899.16	1.66
	Даатгалын гэрээний зардал	231,878.66	253,635.64	-9.38%	266,827.96	13,192.32	1.05
3	Нийт зардлын дүн	3,876,315.93	2,842,691.36	26.67%	4,678,829.98	1,836,138.62	1.65
4	Урсгал зардлын дүн	3,876,315.93	2,842,691.36	26.67%	4,678,829.98	1,836,138.62	1.65
5	Бараа үйлчилгээний зардал	2,059,588.13	2,007,299.26	2.54%	2,747,406.38	740,107.12	1.37
6	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,830,745.00	1,785,102.47	2.49%	2,442,139.00	657,036.53	1.37
	Үндсэн цалин	1,328,400.00	1,354,398.03	-1.96%	1,696,200.00	341,801.97	1.25
	Үндсэн цалин (Экспортын газар)					-	-
	Унаа, хоолны хэнгөлөлт	59,065.00	50,383.00	14.70%	180,109.00	129,726.00	3.57
	Унаа, хоолны хэнгөлөлт (Экспортын газар)					-	-
	Нэмэгдэл урамшил	340,680.00	319,949.14	6.09%	433,830.00	113,880.86	1.36
	Нэмэгдэл урамшил (Экспортын газар)					-	-
	Мэргэжилтнийг ажиллуулах хөлс	102,600.00	60,372.30	41.16%	132,000.00	71,627.70	2.19

7	1.2. АО-с нийгмийн даатгалд төлөх шимтгэл	228,843.13	222,196.79	2.90%	305,267.38	83,070.59	1.37
	1.2. АО-с нийгмийн даатгалд төлөх шимтгэл	228,843.13	222,196.79	2.90%	305,267.38	83,070.59	1.37
8	1.3. Бараа үйлчилгээний бусад зардал	913,077.80	814,542.10	10.79%	1,682,073.60	867,531.50	2.07
	Засвар үйлчилгээний зардал /урсгал засвар/	18,300.00	10,074.87	44.95%	69,400.00	59,325.13	6.89
	Байрны түрээсийн төлбөр /түрээс бусад/	191,900.00	229,659.72	-19.68%	278,780.00	49,120.28	1.21
	Ашиглалтын зардал	600.00	393.80	34.37%	1,250.00	856.20	3.17
	Дотоод албан томилолт	36,000.00	27,697.01	23.06%	60,000.00	32,302.99	2.17
	Гадаад албан томилолт /арга хэмжээ/	15,000.00	-	100.00%	183,342.00	183,342.00	-
	Бичиг хэрэг	8,090.00	5,315.10	34.30%	9,165.00	3,849.90	1.72
	Тээвэр шатахуун	19,040.00	7,094.06	62.74%	28,000.00	20,905.94	3.95
	Шуудан, холбоо	16,640.00	15,001.00	9.85%	18,480.00	3,479.00	1.23
	Ном хэвлэл авах	693.20	-	100.00%	2,720.00	2,720.00	0
	Элэгдлийн зардал	209,532.60	189,971.45	9.34%	209,532.60	19,561.15	1.10
	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл /БҮТЭЗ/ хангамжийн материал	3,542.00	5,631.60	-58.99%	5,768.00	136.40	1.02
	Төлбөр хураамж, бусад төлбөр	81,635.00	88,272.34	-8.13%	105,550.00	17,277.66	1.20
	Хөрөнгө оруулалтын зардал	42,393.00	34,194.61	19.34%	43,750.00	9,555.39	1.28
	Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	63,500.00	-	100.00%	338,500.00	338,500.00	-
	Банк санхүүгийн байгууллагын хураамж	5,000.00	1,783.19	64.34%	6,000.00	4,216.81	3.36
	Мэдээлэл сургалт, сурталчилгааны зардал	215,885.00	188,390.20	12.74%	319,010.00	130,619.80	1.69
	Гадаад зочин таллоогчийн зардал	5,000.00	8,532.57	-70.65%	10,000.00	1,467.43	1.17
	Татвар ногдох орлогоос хасагдахгүй бусад зардал	14,720.00	2,530.58	82.81%	19,576.00	17,045.42	7.74
	Хуваарилагдаагүй зардал	8,000.00	-	100.00%	17,000.00	17,000.00	-
9	2.Татаас ба урсгал шилжүүлэг	903,650.00	20,850.00	97.69%	249,350.00	228,500.00	11.96
9.1	Нэг удаагийн төтгэмж урамшуулал	32,850.00	20,850.00	36.53%	92,400.00	71,550.00	4.43
9.2	Байгалийн гамшиг, ослын үр дагаврыг бууруулах					-	-
9.3	Хувьцаа гаргахтай холбоотой зардал	870,800.00		100.00%	156,950.00	156,950.00	-
	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	913,027.64	3,412,045.40	-273.71%	3,970,611.41	558,566.01	1.16
	Орлогын албан татварын зардал	419,121.97	498,788.29	-19.01%	567,373.55	68,585.26	1.14
	Татварын дарнах ашиг (алдагдал)	493,905.67	2,913,257.11	-489.84%	3,403,237.86	489,980.75	1.17